



СОЁМБО

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

177
/177/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.12

ТУСГАЙ ДУГААР



ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ 100

100 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА



Байлдааны гавьяаны улаан тугийн болон Алтан гадас одонт Цэргийн төв эмнэлгийн түүхт 100 жилийн ой өнөөдөр тохиож буй бөгөөд ойн баярын хурал энэ цаг мөчид МҮЭСТО-д зохион байгуулагдаж байна. Баярын хуралд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, ЭМЯ-ны эмнэлгийн тусламжийн газрын дарга Б.Буянтогтох нарын хүндэт зочид төлөөлөгчид оролцож байгаа юм.

Тэртээ 1921 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Цэргийн төв эмнэлгийн суурийг Бүх цэргийн зөвлөл, Их жанжин Д.Сүхбаатарын тушаал, санаачилгаар “Өвчтэй хүнийг эмчлэх Түвд-Европ

эмнэлгийн холимог хороо” нэртэйгээр, 210 ортой улсын хэмжээний анхны Шинжлэх ухааны эмнэлэг нээгдсэн түүхтэй. Энэ цаг үеэс эхлэн тус эмнэлэг нь анхны гэх тодотголтой олон арван ажил, арга хэмжээ, үйл явдлын эхлэл суурийг тавьсан гэдгийг түүх гэрчилнэ. Тухайлбал, анхны амбулаторын үзлэг, эмчилгээ, мэс заслын, дотрын, уушгины өвчнийг эмчлэх тасгууд нээсэн, эмчилгээ оношилгооны удирдамж заавруудыг боловсруулсан, мэс засал, гэмтлийн чиглэлийн олон арга технологийг нэвтрүүлсэн гээд анхны тодотголтой урт жагсаалт үүснэ. Түүнчлэн цэргийн эмнэлгийн эмч, сувилагч, ажилчид нэгэн зууны түүхэн хугацаанд болсон дайн байлдаан, улс орныг хамарсан гамшиг, халдварт өвчин, дэлхийг хамарсан цар тахал, даян дэлхийн энх тайван,

амар амгаланг тогтоохоор энхийг сахиулах ажиллагаа, энх цагийн бүтээн байгуулалт зэрэгт оролцож олон мянган цэрэг эрс, олон мянган хүмүүний алтан амийг аварсан хос тангарагтаа үнэнчээр зүтгэсэн ачтанууд билээ. Эл түүхэн хугацаанд Цэргийн төв эмнэлэг нь 1955 онд Алтан гадас, 2017 онд Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор тус тус шагнагдсан төдийгүй эгнээнээсээ Монгол Улсын баатар, ардын эмч, төрийн соёрхол, гавьяат эмч, эрдэмтэн докторуудыг хэдэн арваар нь төрүүлэн гаргажээ.

Ийнхүү түүхт 100 жилийнхээ ойтой учран золгож, эл ойгоо ёслол төгөлдөр тэмдэглэн яг энэ цаг мөчид баярын хурлаа зохион байгуулж байна. Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг дараагийн дугаараас хүлээн авч уншина уу.

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын Эрүүлийг хамгаалахын салбарын тулганы чулууг тавьж, түүхэн хөгжлийн түүхээ болсон Цэргийн төв эмнэлэг үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн мэндийг үе үеийн удирдлага, ахмадууд, эмч сувилагч, эмнэлгийн ажилтнууд та бүхэндээ өргөн дэвшүүлбэ.

Нэгэн зууны тэртээ тухайн үеийн Их Хүрээнд жанжин Д.Сүхбаатарын санаачилга, Бүх цэргийн зөвлөлийн хурлын шийдвэрээр “Өвчтэй хүнийг эмчлэх хороо” нэртэйгээр анх байгуулагдаж цэрэг, ардынхаа эрүүл мэндийг сахин хамгаалж эхэлсэн цагаас Монгол Улсын анхны хэвтэн эмчлүүлэх ортой эмнэлэг, анхны амбулатори, анхны эмийн сан, анхны мэс заслын тасаг, уушгины өвчний эмчлэх тасгуудыг байгуулж, гадаад хамтын ажиллагааны эхлэлийг тавьж, эмч эмнэлгийн мэргэжлээр үндэсний боловсон хүчнийг бэлтгэж эхэлсэн гээд эрүүл мэндийн салбарын хөгжлийн анхдагч болохыг гэрчлэх баримтууд түүхэн хуудаснаа тодоор тэмдэглэгдэн үлджээ.

Халхын голын байлдаан, Чөлөөлөх дайн, Баруун хилийн тулгаралтын хүнд бэрх цаг үед ч цэргийн эмнэлэг тэргүүн эгнээнд явж, өвчтөн шархтнуудыг татан гаргаж, эрэмбэлэн ялгаж, хээрийн хөдөлгөөнт госпиталиудыг дэлгэн ажиллуулж, олон цэрэг эрсийн амь насыг аварсан бахархалт түүхтэй.

Энх цагийн бүтээн байгуулалтын жилүүдэд барилга байшин, хүний нөөц, тоног төхөөрөмжийн шинэчлэлүүдийг бодлоготой, шат дараалалтай хэрэгжүүлж, хуримтлуулсан туршлага сургамждаа тулгуурлан, цэргийн эмнэлгийн номлол тактикийг өөрийн орондоо нутагшуулж, олон сурах бичиг, гарын авлагыг боловсруулан гаргаж, эмчилгээний шинэ арга, технологиудыг эх орондоо нэвтрүүлсэн, Монгол Улсын баатар, ардын эмч, төрийн соёрхол, гавьяат эмч, эрдэмтэн докторуудыг хэдэн арваар нь эгнээнээсээ төрүүлэн гаргасан гээд бахархам амжилт, байгуулсан гавьяа дундаршгүй билээ.



ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ДАРГА-ЕРӨНХИЙ ЭМЧ, ДЭД ХУРАНДАА Б.ЭНХ-ОД

Даян дэлхийн энхийн үйлсэд цэргийн эмч нар анхны шанг татаж, дэлхийн халуун цэгүүдэд цэргийн хээрийн нэг, хоёрдугаар шатны эмнэлгийг дэлгэн ажиллуулж, НҮБ-ын цэргийн болон энгийн албан хаагчид, орон нутгийн иргэдэд яаралтай болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгийн тусалж үйлчилгээг тасралтгүй үзүүлсээр байгааг тэмдэглэх нь зүйн хэрэг.

Өнөөдрийн байдлаар Цэргийн төв эмнэлгийн поликлиникээр жилдээ 180,000 гаруй иргэн үйлчлүүлж, стационарт 22,000 гаруй үйлчлүүлэгч хэвтэн эмчлэгдэж, эрүүл мэндийн салбарын ачааны зохих хувийг үүрэлцэж, зорилго нэгтэй хамт олон зогсолтгүй хөгжлийн төлөө урагшилсаар байна.

Дэлхийг хамарсан цар тахал манай орныг нөмөрснөөс хойш өнөөдрийг хүртэл цэргийн эмч нар тэргүүн эгнээнд ажиллаж, 6200 гаруй тахалд нэрвэгдсэн иргэдээ эдгээн илаарьшуулжээ. Цахим шилжилтийн эрин зууны хөгжлөөс хоцролгүй хөл нийлүүлэн алхахын тулд цахим эмнэлэг болж, үйлчлүүлэгчдэд ээлтэй, аюулгүй, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр ур чадвартай, сургалт, судалгааны чансаагаар олон улсын түвшинд хүрсэн, аврахуйн анагаах ухаан, яаралтай тусламжаар үндэсний хэмжээний жишиг эмнэлэг болохоор чармайн ажиллаж байна.

Батлан хамгаалах яамны 110 жил, Ардын хувьсгалын 100, Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ой давхацсан онцлог жил тохиож буй цаг дор Цэргийн Төв эмнэлгийн 100 жилийн ойг тохиолдуулан тус эмнэлгээр эрүүл мэндээ сахин хамгаалуулдаг Зэвсэгт хүчний нийт хамт олондоо баярын мэндчилгээ дэвшүүлж, эрүүл энх, ажлын амжилт, амьдралын сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Монгол цэргийн эмчийн ухаан нь хурц, гар нь уран, амжилт бүтээл нь арвин байг.

Монгол цэргийн сүлд хийморь мөнхөд мандан бадраг.

УРИА

*Батлан хамгаалах нь улс орны баталгаа
Эрүүлийг хамгаалах нь эх орны ирээдүй*



**Эмнэлгийн
үйлчлэх хүрээ**

Тус эмнэлэг нь Монгол Улсын стандарт "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа" MNS 6330:2017-д нийцүүлэн улсын хэмжээний химийн болон эмийн хордлого, галт зэвсэг, нийслэлийн хүйтэн зэвсгийн гэмтлийн тусламж үйлчилгээ, дотор, мэс засал, хүүхэд, эмэгтэйчүүд, хавдар, харшил, халдварт, сэргээн засах, уламжлалт зүү эмчилгээ, нүүр ам шүдний тусламж, үйлчилгээг үзүүлдэг. Мөн Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн алба хаагчдад, тэдний гэр бүлийнхэн, чөлөөнд гарсан ахмадууд, нийслэлийн Баянзүрх, Багахангай дүүргийн насанд хүрсэн иргэдэд мэс заслын тусламж, нийслэлийн БЗД-ийн зарим хороодын харьяа хүүхдүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

**ЭМНЭЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХҮЧИН ЧАДАЛ**

Тус эмнэлэг нь жилд дунджаар 22 000 гаруй үйлчлүүлэгчийг эмчилгээний 22 тасагт хэвтүүлэн эмчилж, 9000 гаруй хүнд мэс заслын тусламж үзүүлж, поликлиникийн үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн 56, оношилгооны 13 кабинет, нэгдсэн лабораториор хоногт дунджаар 120 орчим үйлчлүүлэгч, 750 үзүүлэлтийн шинжилгээ хийдэг. Жилд 130,000 гаруй хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Түүнчлэн удирдлагын болон дэмжих үйлчилгээний 12 тасаг, алба ажиллаж байна.

Цэргийн төв эмнэлэг нь хөгжлийнхөө явцад хэд хэдэн удаа нэршлээ сольж байсан ба энэхүү өөрчлөлтөд эмнэлгийн өөрийн хөгжлөөс гадна удирдах байгууллагуудын болон арми, Зэвсэгт хүчний нэрийн өөрчлөлт ч нөлөөлж байжээ.

- 1.Өвчтөнийг эмчлэх хороо 1921-1924 он
- 2.Цэргийн эмнэлэг (Цэргийн лазер) 1924-1930 он
- 3.Цэргийн госпиталь 1930-1954 он
- 4.Улсын Батлан хамгаалах



яам ба Дотоод явдлын яамны төв госпиталь 1954-1969 он
5.Батлан хамгаалах, Нийгмийг аюулаас хамгаалах яамны төв эмнэлэг 1969-1973 он
6.Монголын Ардын Армийн

Цэргийн төв госпиталь 1973-1983 он
7.Монголын Ардын Армийн клиникийн төв эмнэлэг 1983-1998 он
8.Зэвсэгт Хүчний

Клиникийн Төв Госпиталь 1998-2012 он
9. Батлан Хамгаалах Хууль Сахиулах Алба Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг 2012-2016 он
10.Цэргийн төв эмнэлэг 2016 оноос

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

АЛСЫН ХАРАА:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сургалт, судалгааны чансаагаар олон улсын түвшинд хүрсэн, аврахуйн анагаах ухаан, яаралтай тусламжаар үндэсний хэмжээний жишиг эмнэлэг болно

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Үйлчлүүлэгчдэд ээлтэй, аюулгүй, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр ур чадвартай эмч, мэргэжилтнүүд орчин үеийн шилдэг технологид тулгуурлан үзүүлнэ

ҮНЭТ ЗҮЙЛС:

- Цэргийн албан хаагч, үйлчлүүлэгчдийн эрүүл мэнд
- Харилцан ойлголцол, итгэл, хүндлэл
- Бүтээлч, үр дүнтэй үйл ажиллагаа
- Хүний нөөцийн хөгжил, өндөр ур чадвар
- Хос тангарагтаа үнэнч байх зүтгэл
- Халамж хүндлэл, сэтгэл шингэсэн үйлчилгээ

БАРИМТЛАХ "5Х" ЗАРЧИМ:

Хариуцлага өндөртэй
Хэрэглэгч төвтэй
Хамтын зүтгэлтэй
Хамгаас чанартай
Хүртээмж сайтай тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

БАХАРХАЛ:

-Монгол улсын орчин цагийн эрүүл мэндийн анхдагч, ууган эмнэлэг
-Улс орноо батлах хамгаалах хоёр дайнд оролцсон түүхэн замнал
-Үе үеийн бахархан дуурайх үлгэр жишээч ахмад үе, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд

**ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГЭЭР
ОВОГЛОДСОН МАРК
"МЭНДЭЛЛЭЭ"**



Энэ жил Монгол Улсын батлан хамгаалах салбарт олон түүхэн ой тохиож байгаагийн нэг нь манай орны анагаах ухааны салбарын ууган байгууллагуудын нэг Цэргийн төв эмнэлгийн 100 жилийн ой юм. Тус эмнэлгийн хамт олон энэ түүхэн ойнхоо хүрээнд олон бүтээлч ажил, арга хэмжээг өрнүүлж байгаагийн нэг нь "Цэргийн төв эмнэлгийн 100 жил" сэдэвт анхны маркийг загварчлан гаргаж өнөөдөр нээлтээ хийсэн үйл явдал байлаа.

Тус ёслолын үйл ажиллагаанд БХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга, хурандаа С.Ванчинхүү, Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч, дэд хурандаа Б.Энх-Од, Цэргийн төв эмнэлгийн дарга асан, бэлтгэл хурандаа С.Батболд, ЗХЖШ-ын Захирааны удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Д.Номт, ЗХЖШ-ын Эмнэлгийн хэлтсийн дарга, хурандаа Т.Сүхбаатар болон "Монгол шуудан" ХК-ний Марк, үнэт цаасны хэлтсийн дарга Б.Дамдинбазар нарын хүндэт зочид оролцлоо.

Энэ үеэр Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч, дэд хурандаа Б.Энх-Од "Монгол Улсын хамгийн анхны марк 1924 онд хэвлэгдсэн байдаг бөгөөд үүнээс хойш 97 жилийн хугацаанд нийт 1086 марк хэвлэгдэн гарчээ. Эдгээрийн хамгийн отгон марк нь өнөөдөр "мэндэлж" буй Цэргийн төв эмнэлгийн 100 жилийн ойд зориулсан энэхүү марк юм. Манай эмнэлгийн өнгөрсөн түүхийн он цагийн хэлхээсийг эл маркт тусган загварчилсан нь манай байгууллагын үнэ цэнийг илүүтэйгээр тодотгон харуулсан ач холбогдол бүхий үйл явдал боллоо. Монгол Улсад эрүүл мэндийн салбартай холбоотой маркийг анх 1960 оноос эхлэн гаргасан байдаг

бөгөөд өнөөдөр нээлтээ хийж буй энэ марк анагаах ухааны салбараар овоглодсон найм дахь марк болж байна" гэв. Харин тус маркийг зохион бүтээх ажлыг санаачлан хэрэгжүүлсэн Цэргийн төв эмнэлгийн дарга асан, бэлтгэл хурандаа С.Батболд "Өнгөрсөн нэгэн зууны түүхэнд улс орноо батлан хамгаалах болон ард түмнээ анагаах эрүүл мэндийн салбарт түүчээлэн оролцсон байгууллага бол яах аргагүй манай Цэргийн төв эмнэлэг юм. Тэр ч утгаараа өнөөдөр нээлтээ хийж буй энэ маркт 1921 оны 8 дугаар сарын 15-нд жанжин Д.Сүхбаатарын тушаалаар цэрэг, ард иргэдэд үнэ төлбөргүй үйлчлэхээр байгуулагдсан анхны эмнэлгээс эхлээд улс оронд өрнөсөн дайны он жилүүдэд хэрхэн үүрэг гүйцэтгэж байсан, НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд II шатлалын эмнэлгийн гүйцэтгэсэн үүрэг, үйл ажиллагаа, цар тахлын



үеийн онцгой нөхцөлд тэргүүн шугамд ажилласан эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан, албан хаагчдыг дүрслэн харуулсан" хэмээн онцлолоо.

УУШГИ ОРЛУУЛАХ АППАРАТ БУЮУ ЕСМО-АППАРАТЫН ТУХАЙ



ЕСМО (extracorporeal membrane oxygenation) гэдэг нь биеэс гадна мембранаар хүчилтөрөгчжүүлэх гэсэн утгатай. Уушги нь хүний биед хуримтлагдсан нүүрс хүчлийн хийг гадагшлуулан, цусыг хүчилтөрөгчөөр баяжуулаад зүрхний агшилтаар эд, эрхтэнд хүчилтөрөгчийг түгээх үүрэгтэй байдаг бол ЕСМО аппарат нь уушгины эмгэгийн үед өвчтөний цусыг уушгинд бус, биеэс гадна орчинд нүүрс хүчлийн хийг шүүж, хүчилтөрөгчөөр баяжуулан, бүлээсгээд эд эрхтэнд түгээснээр уушги, зүрхний ачааллыг тодорхой хугацаанд бууруулж өгдөг байна. 1944 онд хиймэл бөөрний гялгар уутан дундуур өнгөрсөн цус хүчилтөрөгчөөр баяжигдаж байгаа тухай Kolff and Berk нар тэмдэглэсэн бол энэ онолыг анх удаа 1953 онд Gibbon хиймэл хүчилтөрөгчжүүлэлтийг зүрхний нээлттэй хагалгаанд амжилттай нэвтрүүлсэн. 1965 онд Rashkind болон хамтрагчид нь амьсгалын дутагдлаас болж нас барж байсан нярайд хөөсөн хүчилтөрөгчийг анх хэрэглэсэн бол 1970 онд Baffes болон хамтрагчид нь төрөлхийн зүрхний гажигтай нярайн зүрхний хагалгаанд ЕСМО-г анх удаа амжилттай ашигласан тухай тэмдэглэсэн байдаг. 1972 онд гэмтлийн гаралтай, амьсгалын хүнд хэлбэрийн дутагдалтай өвчтөнд ЕСМО-г удаан хугацаагаар амжилттай хэрэглэсэн байна. 1975 онд Bartlett нөхдийн хамт амьсгалын хүнд хэлбэрийн дутагдалтай нярайд ЕСМО-н аппаратаар амжилттай эмчилсэн. Үүнээс дүгнэхэд 1944 оноос эхлэн туршилт судалгаа хийсээр 1970-аад оноос уушги орлуулах аппарат буюу ЕСМО-г орчин үеийн анагаах

ухаанд өргөн ашиглаж эхэлжээ. 2019 оны сүүлчээр БНХАУ-аас эхтэй дэлхий даяар цар тахал болон тархсан шинэ коронавирүсийн халдвар нь уушгины хүнд хэлбэрийн хатгалгаа үүсгэж амьсгалын цочмог дутагдлаар хүндэрч, олон хүнийг үхэлд хүргэж эхэлснээр уушги орлуулах аппаратын эрэлт хэрэгцээ эрс нэмэгдсэн. ХБНГУ-ын БХЯ-ны буцалтгүй тусламжаар манай эмнэлэгт ЕСМО аппарат бэлэглэснээр Монгол Улсын хэмжээнд уушги орлуулах аппараттай хоёрдох эмнэлэг болсон. Цэргийн Төв Эмнэлэг нь шинэ коронавирүсийн халдварын батлагдсан тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг 2020 оны 11 дүгээр сарын 12-ноос эхлэн өнөөдрийг хүртэл 6100 гаруй үйлчлүүлэгчийг эмчлэн эдгэрүүлээд байна. Энэ хугацаанд тус эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт хэвтсэн уушги орлуулах эмчилгээ хийх заалттай маш хүнд 5 өвчтөнийг ЕСМО аппаратаар эмчилснээс 3 хүний амь насыг аварч эмчлэн эдгэрүүлсэн амжилттай ажиллаж байна. Энэ нь Монгол Улсын хэмжээнд шинэ коронавирүсийн халдвартай өвчтөнийг ЕСМО аппаратаар эмчилсэн анхны тохиолдол юм. 2021 оны 4 дүгээр сараас 11 дүгээр саруудад Ковид-19 халдварын нэн хүнд хэлбэрийн хатгалгаатай, 30-65 насны 5 хүний уушгийг ЕСМО аппаратаар орлуулан, эмийн эмчилгээг үргэлжлүүлэхэд 40 хувь нь биеийн байдал сайжирч, хэвийн амьдралдаа шилжсэн. Одоогоор 20 хувь буюу 1 нэн хүнд эмчлүүлэгч ЕСМО аппаратын тусламж үйлчилгээг авч байна.